



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 6/01

Хэрлэн сум

Х.Баярбаатарыг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч Э.Ариунтунгалаг нь жирэмсний болон амаржсаны амралт авсан тул Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн орлого, хөрөнгө оруулалтын санхүүжилт хариуцсан мэргэжилтэн Халтарын Баярбаатарыг Нягтлан бодогчийн албан тушаалд 2024 оны 1 дгээр сарын 02-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2.Х.Баярбаатарын ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын
дарга:

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн
дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн

Аймгийн төсвийн ерөнхийлөн
захирагчийн төсвийн ерөнхий
нягтлан бодогч

Д.Энхтуяа

Архив, Бичиг хэргийн эрхлэгч

3.Х.Баярбаатарт нягтлан бодогчийн ажлыг түр орлон гүйцэтгэсний цалинг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4.Байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Х.Баяртбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА

